



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/107/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 99029193 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 99035990 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Ариунбаяр Утас: 99076224 Цахим хаяг: ariunbayars@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.8.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Зөвлөмж.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НББ	Нягтлан бодох бүртгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ
СУМЫН 7 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Х.ДЭЛГЭР ТАНАА

Х.Д. Д.Т. 25 № 68

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>35,905,573.26</u>	<u>39,283,091.00</u>
33	АВЛАГА	3,448,790.26	00.00
335	Бусад авлага	3,448,790.26	00.00
3351	Байгууллагаас авах авлага	3,448,790.26	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,456,783.00	39,283,091.00
351	Түүхий эд материал	998,450.00	1,125,450.00
35130	Эм боох материал	998,450.00	1,125,450.00
354	Хангамжийн материал	29,338,333.00	34,917,641.00
35420	Аж ахуйн материал	00.00	65,400.00
35460	Хүнсний материал	00.00	845,248.00
35470	Бусад хангамжийн материал	29,338,333.00	34,006,993.00
35600	Мал амьтад	2,120,000.00	3,240,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>101,484,800.69</u>	<u>97,734,863.34</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	101,484,800.69	97,734,863.34
392	Биет хөрөнгө	77,712,800.69	73,962,863.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	82,146,813.56	82,146,813.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	-12,007,203.60	-18,010,805.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	12,868,900.00	17,667,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9,708,449.66	-11,439,716.25
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,732,976.00	22,732,976.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,785,849.49	-21,599,918.45
39217	Ном	2,465,613.88	2,465,613.88
393	Биет бус хөрөнгө	23,772,000.00	23,772,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	23,772,000.00	23,772,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>137,390,373.95</u>	<u>137,017,954.34</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>926,096.63</u>	<u>1,893,934.24</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	926,096.63	1,893,934.24
413	Өглөг	926,096.63	1,893,934.24
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	575,081.63	1,879,934.24
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	187,825.00	00.00
4136	Бусад өглөг	163,190.00	14,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	163,190.00	14,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>136,464,277.32</u>	<u>135,124,020.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	136,464,277.32	135,124,020.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	65,166,184.62	65,166,184.62
51101	Өмч: - төрийн	65,166,184.62	65,166,184.62
512	Хуримтлагдсан үр дүн	-1,334,190.57	-2,674,447.79
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,334,190.57	-1,616,208.57
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,058,239.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	72,632,283.27	72,632,283.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>137,390,373.95</u>	<u>137,017,954.34</u>

Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	290,075,500.00	306,900,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,834,300.00	36,921,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,120,000.00	6,739,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,120,000.00	6,739,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,120,000.00	6,739,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	28,714,300.00	30,182,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	28,714,300.00	30,182,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	1,050,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	259,241,200.00	268,929,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,050,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,050,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	286,171,501.84	305,839,139.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	286,171,501.84	305,839,139.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	284,245,941.78	296,619,354.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,540,356.54	216,583,850.84
210101	Үндсэн цалин	188,077,494.19	133,678,429.35
210102	Нэмэгдэл	988,254.00	61,969,141.99
210104	Урамшуулал	12,474,608.35	20,936,279.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,440,032.57	27,897,113.85
210201	Тэтгэврийн даатгал	17,902,245.14	20,236,995.16
210202	Тэтгэмжийн даатгал	1,730,933.86	1,860,545.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,661,070.49	1,586,508.03
210204	Ажилгүйдлийн даатгал	376,889.37	383,006.10
210205	Эрүүл мэндийн даатгал	3,768,893.71	3,830,059.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,680,982.00	23,453,332.56
210301	Гэрэл, цахилгаан	1,844,984.00	2,511,678.56
210302	Түлш, халаалт	17,321,920.00	18,559,200.00
210303	Цэвэр, бохир ус	2,514,078.00	2,382,454.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,670,690.00	2,636,830.00
210401	Бичиг хэрэг	282,600.00	761,500.00
210402	Тээвэр, шатахуун	340,000.00	180,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	172,700.00	150,000.00
210404	Ном, хэвлэл	47,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	828,390.00	1,545,330.00
2105	Нормативт зардал	19,876,954.22	12,675,090.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,337,000.00	1,026,400.00
210502	Хоол, хүнс	18,120,614.22	11,422,415.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	419,340.00	226,275.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,993,100.00	3,340,000.00
210604	Урсгал засвар	2,993,100.00	3,340,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,000.00	1,284,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	814,000.00	1,284,200.00

Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,229,826.45	8,748,937.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	170,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,685,150.00	30,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,544,676.45	8,548,937.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,925,560.06	9,219,784.62
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	468,425.06	5,490,517.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	468,425.06	5,490,517.18
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,457,135.00	3,729,267.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,457,135.00	3,729,267.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>3,903,998.16</u>	<u>1,061,760.78</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,460,000.00	2,120,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,460,000.00	2,120,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,460,000.00	-2,120,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,443,998.16</u>	<u>-1,058,239.22</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,394,184.62	00.00	-1,960,367.99	39,433,816.63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,394,184.62	00.00	-1,960,367.99	39,433,816.63
C07	Тайлант үеийн үр дүн	23,772,000.00	00.00	10,946,633.25	34,718,633.25
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,166,184.62	72,632,283.27	-1,334,190.57	136,464,277.32
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,166,184.62	72,632,283.27	-1,334,190.57	136,464,277.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-282,018.00	-282,018.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	65,166,184.62	72,632,283.27	-1,616,208.57	136,182,259.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,058,239.22	-1,058,239.22
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,166,184.62	72,632,283.27	-2,674,447.79	135,124,020.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>288,526,840.07</u>	<u>300,161,900.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,714,300.00	30,182,600.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	28,714,300.00	30,182,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	28,714,300.00	30,182,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	259,812,540.07	269,979,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	259,241,200.00	268,929,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	571,340.07	1,050,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	571,340.07	1,050,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>288,526,840.07</u>	<u>298,861,900.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288,526,840.07	298,861,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	286,601,280.01	289,642,115.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202,469,742.01	212,116,454.90
210101	Үндсэн цалин	141,327,231.14	129,281,625.96
210102	Нэмэгдэл	36,041,143.52	62,189,734.54
210104	Урамшуулал	25,101,367.35	20,645,094.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,328,700.00	27,896,884.92
210201	Тэтгэврийн даатгал	20,154,500.00	19,373,997.67
210202	Тэтгэмжийн даатгал	2,043,600.00	2,130,721.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,634,800.00	1,704,577.28
210204	Ажилгүйдлийн даатгал	408,700.00	426,144.56
210205	Эрүүл мэндийн даатгал	4,087,100.00	4,261,443.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,264,065.00	23,453,332.56
210301	Гэрэл, цахилгаан	1,844,984.00	2,511,678.56
210302	Түлш, халаалт	17,321,920.00	17,283,092.00
210303	Цэвэр, бохир ус	5,097,161.00	3,658,562.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,913,300.00	1,295,500.00
210401	Бичиг хэрэг	282,600.00	208,800.00
210402	Тээвэр, шатахуун	340,000.00	180,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	172,700.00	150,000.00
210404	Ном, хэвлэл	47,000.00	48,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,071,000.00	708,500.00
2105	Нормативт зардал	21,470,423.00	14,015,278.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,041,000.00	223,900.00
210502	Хоол, хүнс	16,641,073.00	12,491,788.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,788,350.00	1,299,590.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,993,100.00	3,900,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	900,000.00
210604	Урсгал засвар	2,993,100.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,400,800.00	5,992,965.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,400,800.00	5,992,965.00

Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,761,150.00	971,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	890,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,761,150.00	81,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,925,560.06	9,219,784.62
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	468,424.99	5,490,517.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	468,424.99	5,490,517.18
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,457,135.00	3,729,267.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,457,135.00	3,729,267.44
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.07	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.07	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>1,300,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,300,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-1,300,000.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	299,111,900.00	289,892,115.38	9,219,784.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	299,111,900.00	289,892,115.38	9,219,784.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	299,111,900.00	289,892,115.38	9,219,784.62
2101	Цалин хөлс нэмэгдэл урамшил	212,350,200.00	212,116,454.90	233,745.10
210101	Үндсэн цалин	152,810,200.00	129,281,625.96	23,528,574.04
210102	Нэмэгдэл	38,760,200.00	62,189,734.54	-23,429,534.54
210104	Урамшуулал	20,779,800.00	20,645,094.40	134,705.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,556,700.00	27,896,884.92	659,815.08
210201	Тэтгэврийн даатгал	20,480,600.00	19,373,997.67	1,106,602.33
210202	Тэтгэмжийн даатгал	2,019,000.00	2,130,721.95	-111,721.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,615,200.00	1,704,577.28	-89,377.28
210204	Ажилгүйдлийн даатгал	403,800.00	426,144.56	-22,344.56
210205	Эрүүл мэндийн даатгал	4,038,100.00	4,261,443.46	-223,343.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,182,600.00	23,453,332.56	3,729,267.44
210301	Гэрэл, цахилгаан	2,524,300.00	2,511,678.56	12,621.44
210302	Түлш, халаалт	18,790,200.00	17,283,092.00	1,507,108.00
210303	Цэвэр, бохир ус	5,868,100.00	3,658,562.00	2,209,538.00
2104	Хангамж, бараа материал зардал	1,295,800.00	1,295,500.00	300.00
210401	Бичиг хэрэг	208,800.00	208,800.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	180,000.00	180,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэт төлбөр	150,300.00	150,000.00	300.00
210404	Ном, хэвлэл	48,200.00	48,200.00	0.00

Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	708,500.00	708,500.00	0.00
2105	Нормативт зардал	18,341,200.00	13,865,278.00	4,475,922.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,900.00	73,900.00	0.00
210502	Хоол, хүнс	16,967,700.00	12,491,788.00	4,475,912.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,299,600.00	1,299,590.00	10.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	0.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	117,000.00	00.00	117,000.00
210702	Дотоод албан томилолт	117,000.00	00.00	117,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,993,900.00	5,992,965.00	935.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,993,900.00	5,992,965.00	935.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2274500.00	2271700.00	2,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	893,000.00	890,200.00	2,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,381,500.00	1,381,500.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	299,111,900.00	289,892,115.38	9,219,784.62
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	268,929,300.00	263,438,782.82	5,490,517.18
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	268,929,300.00	263,438,782.82	5,490,517.18
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,182,600.00	26,453,332.56	3,729,267.44
132001	Орон нутгийн төсвөөс	30,182,600.00	26,453,332.56	3,729,267.44
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,050,000.00	(1,050,000.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,050,000.00	(1,050,000.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,050,000.00	(1,050,000.00)
2105	Нормативт зардал		150,000.00	(150,000.00)
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		150,000.00	(150,000.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		900,000.00	(900,000.00)
210601	Багаж, техник, хэрэгсэл		900,000.00	(900,000.00)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	1,050,000.00	(1,050,000.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,050,000.00	(1,050,000.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,050,000.00	(1,050,000.00)

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Ариунбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 286,171.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,292.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,219.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 372.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Бараа материал	32,456.8	39,283.1	6,826.3
Үндсэн хөрөнгө	101,484.8	97,734.9	(3,749.9)
Нийт хөрөнгө	137,390.5	137,017.9	372.4
Өр төлбөр	926.1	1,893.9	967.8
Засгийн газрын хувь оролцоо	136,464.3	135,124.0	(1340.3)
Тайлант үеийн үр дүн	-	1,058.2	1,058.2
Өр төлбөр, цэвэр өмчийн дүн	137,390.5	137,017.9	372.4

- Бараа материал данс өмнөх оноос 6,826.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 28,375.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 21,549.1 мянган төгрөгийн материал зарцуулсан бөгөөд аж ахуйн зориулалттай материал худалдан авч үлдээгдлээр тайлагнасан нь бараа материал дансны үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө данс өмнөх оноос 3,749.9 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,300.0 мянга, үнэ төлбөргүйгээр 3,499.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.
- Өр төлбөр өмнөх оноос 967.8 мянган төгрөгөөр өссөн, тайлант онд 1,304.8 мянган төгрөгийн татварын өр үүссэн нь нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 268,929.3 мянга, орон нутгийн төсвөөс 30,182.6 мянга нийт 299,111.9 мянган төгрөгийг төлөвлөж, бүрэн санхүүжүүлсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн нийт зарлагыг 289,892.1 мянган төгрөгөөр илэрхийлж төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 9,219.8 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн дансанд төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлээр гарсан нийт зардлын 240,013.3 мянган төгрөг буюу 82.8 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоо нийгмийн даатгалд төлөх шимтгэл эзэлж байгаа бол 49,878.8 мянган төгрөг буюу 17.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал зэрэг бусад зардлууд эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн дансаар 1,050.0 мянган төгрөг төвлөрч, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад 150.0 мянга, багаж, техник хэрэгсэл худалдан авахад 900.0 мянган төгрөгийг тур тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 88.3 хувьтай тайлагнасан бөгөөд зарим төлөвлөсөн арга хэмжээг ковид цар тахлын улмаас хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал ажиглагдаагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих мэдээллээс 135 мэдээллийг хугацаанд нь 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Харин урсгал санхүүжилтийн 35 гүйлгээний 274,703.6 мянга, өр төлбөрийн 1,893.9 мянган төгрөгийг мэдээлээгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,846.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 280.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, дотоод хяналт, шилэн дансны мэдээлэл болон бараа материалын данстай холбоотой 3 зөвлөмж хүргүүлж, шийдвэрийн биелэлтийг 2021 оны ...тоот албан бичгээр ирүүлсэн байна. Төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн боловч шилэн дансны мэдээллийг цахимд хугацаанд нь мэдээлэх талаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7,813.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 282.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,531.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Өмнөх оны барагдуулсан авлагыг данс бүртгэлд үлдээгдлээр тайлагнасныг залруулж данс бүртгэлээс хассан;

4.2 Албан шаардлага

- Шилэн дансны цахим системд урсгал санхүүжилтийн 35 гүйлгээний 274,703.6 мянга, өр төлбөрийн 1,893.9 мянган төгрөгийг мэдээлээгүй мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4¹, 6.4.5²-т заасныг зөрчиж тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хахгахгүй байна;

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данс бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх онд зарцуулсан 1,120.0 мянган төгрөгийн бараа материалыг /засварт зарцуулсан дүүжин тааз, ламферин тааз гэх мэт/ нягтлан бодогч зарлагдаагүйгээс үлдээгдлээр илэрхийлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Өмнөх онд зарцуулсан материалыг нярвын тайлангийн анхан шатны баримтад үндэслэн данс бүртгэлээс хасаж, үлдээгдлийг үнэн зөв илэрхийлэх;

¹ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

² цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

2. Бараа материалын данс бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд 2,966.5 мянган төгрөгийн аж ахуйн материал, бараа материалын дансанд 595.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж, бараа материал болон үндсэн хөрөнгийн үлдээдлийг буруу илэрхийлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн ангиллаар буруу бүртгэгдсэн хөрөнгө, аж ахуйн материалыг данс хооронд шилжүүлэн бүртгэх;

3. Үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 76 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах;

4. Үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд 2,850.0 мянган төгрөгийн хашаа давхар бүртгэгдсэн байна.

Өгсөн зөвлөмж: давхар бүртгэгдсэн хөрөнгийг эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж данс бүртгэлээс хасах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цэцэрлэг	5	7,813.5	1	282.0			1	0	4	7,531.5
	ДҮН	5	7,813.5	1	282.0			1	0	4	7,531.5